



2018 оны 03 дугаар сарын 05
№09/1014/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Банкин дахь мөнгөн
хадгаламжийн даатгалын
тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Монгол Улсын Их Хурлын
2018 оны хаврын ээлжит
чуулганаар хэлэлцэх
асуудлын тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Прокурорын тангараг
өргөх ёслолын журам
батлах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

97.	Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	293
98.	Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай	299
99.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	299
100.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	301

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

101.	Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 23	302
------	--	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

102.	Прокурорын тангараг өргөх ёслолын журам батлах тухай	Дугаар 07	304
103.	Прокурорын зэрэг дэв тогтоох, олгох журам батлах тухай	Дугаар 08	307

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт:

“3.1.8. “санхүүгийн дэмжлэг” гэж банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны актив, пассивыг шилжүүлэн



авч байгаа банкинд актив, пассивын зөрүүг нөхөх, эсхүл тусгай зориулалтын банкны өөрийн хөрөнгөд хөрөнгө оруулах зорилгоор Хадгаламжийн даатгалын корпорациас мөнгөн хөрөнгө шилжүүлэхийг;”

2/5 дугаар зүйлийн 5.4.3 дахь заалт:

“5.4.3.Энэ хуулийн 11.1.2-т зааснаар шилжүүлэн авч байгаа банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.”

3/6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:

“6.4.Энэ хуулийн 11.1.2-т зааснаар санхүүгийн дэмжлэг үзүүлсэн тохиолдолд хадгаламж эзэмшигчийн нөхөн төлбөрийг олгосонд тооцно.”

4/9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг:

“9.5.Насанд хүрээгүй хамтарсан данс эзэмшигчийн даатгалын нөхөн төлбөр авах эрх тухайн хадгаламжийг бусад этгээдтэй хамтран эзэмшиж байгаагаар хязгаарлагдахгүй.”

5/10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалт:

“10.2.10.нөхөн төлбөр олгох хугацаа дууссаны дараа энэ хуулийн 16.1-д заасан банкинд үлдсэн нөхөн төлбөрийн хөрөнгө;”

6/17 дугаар зүйлийн 17.4-17.6 дахь хэсэг:

“17.4.Хадгаламж эзэмшигчийн даатгалын нөхөн төлбөр авах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа энэ хуулийн 6.3-т заасан шаардах эрх үүссэнээс хойш гурван жил байна.

17.5.Банк нэгтгэх, нийлүүлэх, банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны актив, пассивыг шилжүүлэх байдлаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд ийнхүү өөрчлөн байгуулагдахаас өмнөх банк тус бүрд даатгалын нөхөн төлбөрт олгох хэмжээг тогтоох бөгөөд энэ нь өөрчлөн байгуулагдсанаас хойш зургаан сарын хугацаанд хүчинтэй байна.

17.6.Энэ хуулийн 17.5-д заасан хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг банк тус бүрд тооцох хугацаа дуусч байгаа тухай хадгаламж эзэмшигчид хүлээж авсан, нэгдсэнээс үүссэн банк мэдэгдэнэ.”

7/21 дүгээр зүйлийн 21.1.7, 21.1.8 дахь заалт:

“21.1.7.энэ хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд банкинд хяналт шалгалт хийх;

21.1.8.энэ хуульд заасан мэдээллийг солилцоход шаардагдах программ хангамжийн бүрэн бүтэн, бэлэн байдлыг корпораци нь тогтмол шалгах.”

8/25' дүгээр зүйл:

“25'дүгээр зүйл.Корпорацийн хяналт

25¹.1.Корпораци хянан шалгагчтай байна. Хянан шалгагч нь улсын байцаагчийн дараахь бүрэн эрхтэй байна:

25¹.1.1.энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан тайлан, мэдээ, мэдээллийг банкнаас гаргуулан авах;

25¹.1.2.хадгаламжийн даатгалын хураамж төлөлтөд хяналт тавьж, биелэлтийг хангуулах;

25¹.1.3.даатгалын нөхөн төлбөр төлөх үйл ажиллагаанд хяналт тавих;

25¹.1.4.хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэх арга хэмжээ авах.

25¹.2.Корпорацийн гүйцэтгэх захирал нь улсын ахлах байцаагч байх бөгөөд улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Монголбанкны Ерөнхийлөгч олгож, цуцална.”

2 дугаар зүйл.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “тухайн банкинд төлбөл зохих” гэсний дараа “90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “нэг дансанд” гэсний дараа “энэ хуулийн 15.4-д заасан ханшаар тооцож” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.6 дахь заалтын “нөхөн төлбөр төлөх” гэсний дараа “, энэ хуулийн 11.1.2-т заасан санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт:**

“3.1.2.“хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа” гэж энэ хуульд заасны дагуу банкнаас харилцах болон хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг Хадгаламжийн даатгалын корпорацид даатгуулах, даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлөх, банкны актив, пассивыг шилжүүлэх, тусгай зориулалтын банк байгуулах үед шилжүүлэн авч байгаа банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг;”

2/3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт:

“3.1.4.“хадгаламж” гэж банкин дахь харилцах болон мөнгөн хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг;”

3/3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт:

“3.1.6.“даатгалын тохиолдол” гэж Банкны тухай хуульд заасны дагуу Монголбанк банкныг албадан татан буулгах тухай шийдвэр гаргасныг;”

4/6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг:

“6.1.Энэ хуулийн 3.1.6-д заасан шийдвэр гарсан өдрийг даатгалын тохиолдол бий болсон өдөрт тооцно.

6.2.Монголбанк нь энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргамагц энэ тухай Хадгаламжийн даатгалын корпорацид мэдэгдэх үүрэгтэй.”

5/11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт:

“11.1.2.банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны актив, пассивыг шилжүүлэн авч байгаа банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;”

6/11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг:

“11.2.Энэ хуулийн 11.1.2-т заасан санхүүгийн дэмжлэг, түүнтэй холбоотой гарах зардлын нийлбэр нь даатгалын нөхөн төлбөр олгоход шаардагдах хөрөнгө, түүнтэй холбоотой гарах зардлын нийлбэрээс бага байх тохиолдолд санхүүгийн дэмжлэгийг үзүүлнэ.”

7/14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг:

“14.4.Энэ хуулийн 14.1-д заасан аргачлалыг Монголбанк, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батлах бөгөөд банкны эрсдэлийн түвшинг тооцохдоо банкинд хийсэн хяналт шалгалтын үнэлгээ, банкны хадгаламжийн хүүг харгалзан үзэж болно.”

8/15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг:

“15.3.Хадгаламжийн даатгалын корпораци даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш даатгалын нөхөн төлбөрийг энэ хуулийн 16.1-д заасан банкаар дамжуулан ажлын 10 өдрийн дотор олгож эхэлнэ.”

9/17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг:

“17.3.Өв залгамжлалаар даатгалын нөхөн төлбөр авахад өвлөгч нь өөрийн нэр дээр хадгалуулсан хадгаламж, өвлөгдсөн хадгаламж тус бүрд даатгалын нөхөн төлбөр авна.”

10/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:

“19.3.Корпорацийн дүрмийг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.”

11/21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалт:

“21.1.5.хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Сангийн хөрөнгө хүрэлцэхгүй бол Монголбанк, Засгийн газраас зээл, санхүүгийн дэмжлэг авч болно;”

12/22 дугаар зүйлийн 22.2.3 дахь заалт:

“22.2.3.Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос нэр дэвшиж томилогдсон Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн;”

13/22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэг:

“22.6.Үндэсний хорооны ажиллах журам, Үндэсний хорооны гишүүн, Корпорацийн гүйцэтгэх захирал болон ажилтны ёс зүйн дүрмийг Үндэсний хорооны тогтоолоор батална.”

14/22 дугаар зүйлийн 22.8 дахь хэсэг:

“22.8.Энэ хуулийн 22.2.4-т заасан гурван гишүүнийг нэгэн зэрэг томилж, чөлөөлөхгүй байх зарчмыг баримтална.”

**15/23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг:**

“23.4.Үндэсний хороо улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд хэлэлцэх асуудлаар гишүүдийн саналыг цахим болон бусад хэлбэрээр авч болох ба үндэсний хорооны гишүүн жилд хоёроос доошгүй удаа хуралд биечлэн оролцох үүрэгтэй.”

16/25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг:

“25.6.Энэ хуулийн 22.7-д заасан үндэслэлээр Корпорацийн гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тохиолдолд дараагийн гүйцэтгэх захирал томилогдох хүртэл хугацаанд Үндэсний хорооноос үүрэг гүйцэтгэчийг томилно.”

17/26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг:

“26.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд Үндэсний хорооны гишүүн, Корпорацийн ажилтан, хянан шалгагч болон Корпорацид гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа этгээд албан үүргийнхээ дагуу олж мэдсэн, Корпораци, банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээ, мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.”

18/27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг:

“27.1.Корпорацийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу гаргаж, аудит хийлгэнэ.”

4 дүгээр зүйл.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134.9-д” гэснийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “AAA” гэснийг “А” гэж, 13 дугаар зүйлийн 13.5, 13.10, 13.11 дэх хэсгийн “7.1-д” гэснийг “7.1, 7.2.2, 7.2.3-т” гэж, 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсгийн “хяналтын” гэснийг “аудитын” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалтын “хяналт тавих.” гэснийг “хяналт тавих,” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.10 дахь заалтын “хяналтын албаны шалгалтын” гэснийг “аудитын тайлангийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “дөрвөн” гэснийг “таван” гэж, 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийн “4 дүгээр” гэснийг “6 дугаар” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалтын дугаарыг “10.2.11” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1 дэх заалтын “татан буулгаж байгаа банкны хадгаламж эзэмшигчдийн” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 7.2.9 дэх заалт нэмсүгэй:

“7.2.9.Хадгаламжийн даатгалын корпорацийн хянан шалгагч Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг нэмсүгэй:

“7.Банк нь корпорацийн хүсэлтээр шаардлагатай нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгөөгүй бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Банк нь Үндэсний хорооноос баталсан банкны тайлан, мэдээ, мэдээлэл ирүүлэх журам зөрчсөн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Банк нь дутуу, эсхүл буруу мэдээ, мэдээллийг ирүүлсэн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



10.Банк нь Үндэсний хорооноос баталсан журмын дагуу хадгаламжийн даатгалын тогтолцоо, даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ, түүнийг тооцох хугацааны талаархи мэдээллээр хадгаламж эзэмшигчийг хангах үүргээ биелүүлээгүй, эсхүл хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар буруу мэдээлэл хүргэсэн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Банк нь энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан мэдээллийг зар сурталчилгааны зорилгоор, эсхүл банкны салбарын тогтвортой байдал, хадгаламж эзэмшигчдийн итгэлд сөргөөр нөлөөлөх байдлаар ашигласан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “ажилтан,” гэсний дараа “хянан шалгагч,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.12 дугаар зүйлийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/11.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Монголбанкны хяналт шалгалтын тайлангаар банкны санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн, эсхүл банкны үйлчилгээ авахдаа санхүүгийн давуу эрх эдэлсэн нь тогтоогдсон хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлсөн, эсхүл даатгалын нөхөн төлбөр олгох банкинд зориудаар худал мэдээлэл өгсөн, эсхүл уг мэдээллийг ашиглан даатгалын нөхөн төлбөр олгосон бол ажилтныг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2/11.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Банк нь хадгаламжийн даатгалын корпораци хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг банк тогтоосон хэлбэрээр, хугацаанд нь хадгаламжийн даатгалын корпорацид хүргүүлээгүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “нэмсэнтэй” гэснийг “нэмсэн хувиар үржүүлсэн дүнтэй” гэж, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “7” гэснийг “12” гэж, мөн хэсгийн “Даатгалын” гэснийг “Банк нь даатгалын” гэж тус тус өөрчилсүгэй.



5 дугаар зүйл.Энэ хуулийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 6.28 дахь заалт нэмсүгэй.

“6.28.Хадгаламжийн даатгалын корпорацийн хянан шалгагч Зөрчлийн тухай хуулийн 11.12 дугаар зүйлийн 5-12 дахь хэсэгт заасан зөрчил.”

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.14 дэх заалтын “11.12 дугаар зүйлийн 6.6 дахь заалт” гэснийг “11.12 дугаар зүйлийн 11 дэх хэсэг” гэж, мөн хэсгийн 6.19 дэх заалтын “11.8, 11.12” гэснийг “11.8 дугаар зүйл, 11.12 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг,” гэж, мөн хэсгийн 6.27 дахь заалтын “зөрчил.” гэснийг “зөрчил;” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 23

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл;

2/“Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан;

3/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт;

4/“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

5/Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

6/Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;

7/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл;

8/Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

9/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;



10/Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

11/Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

12/Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

13/Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

14/Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

15/"Монгол Улсад 2018-2020 онд цагаачлуулж болох гадаад иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

16/Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн төсөл;

17/Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

18/Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

19/Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

20/Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

21/Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

22/Баяжуулсан хүнсний тухай хуулийн төсөл;

23/Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

24/бусад.



2.Хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүрд шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлбэл хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболдод зөвшөөрсүгэй.

4.Монгол Улсын Их Хурлын 2018 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Ц.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 01 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Прокурорын тангараг өргөх ёслолын журам батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Прокурорын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. “Прокурорын тангараг өргөх ёслолын журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.



2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” (Прокурорын тангараг өргөх ёслолын журам) Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 125 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны
1 дүгээр сарын 31-ний өдрийн 07 дугаар
зарлигийн хавсралт

**ПРОКУРОРЫН ТАНГАРАГ ӨРГӨХ
ЁСЛОЛЫН ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын ерөнхий прокурорын газар, түүний харъяа аймаг, нийслэл, дагнасан, дүүрэг, сум буюу сум дундын прокурорын газар нь прокурорын тангараг өргөх ёслолын ажиллагаанд энэхүү журмыг баримтална.

1.2. Монгол Улсын иргэн прокурорын албан тушаалд томилогдохдоо Прокурорын тухай хуульд заасан прокурорын тангараг /Цаашид “Тангараг” гэнэ./-ийг өргөнө.

Хоёр. Тангараг өргөх ёслолын ажиллагаа

2.1. Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга, аймаг, нийслэл, дагнасан, сум буюу сум дундын, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор нь прокурорын албан тушаалд шинээр томилсон Улсын Ерөнхий прокурорын тушаал гарснаас хойш нэн даруй буюу ажлын 5 өдрийн дотор тангараг өргөх ёслолыг зохион байгуулна.

2.2. Тангараг өргөх ёслолын ажиллагаа болох танхимыг тусгайлан бэлтгэж, Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбаа, прокурорын байгууллагын бэлгэдэл, далбааг байрлуулсан байна.

2.3. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд тухайн прокурорын газрын прокуроруудыг байлцуулахын зэрэгцээ ахмад прокурор, нутгийн өөрөө удирдах ёсны болон төр, захиргаа, шүүх эрх мэдэл, хууль сахиулах, хууль хяналтын байгууллагуудын удирдлага, төлөөллийг урьж оролцуулна.



2.4. Тангараг өргөх ёслолын ажиллагааг тухайн прокурорын газрын ерөнхий прокурорын тушаалаар томилсон прокурор удирдан явуулна.

2.5. Тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа прокурор нь тангараг өргөх ёслолын ажиллагааг нээж, прокурорын албан тушаалд томилогдсон прокурорыг товч танилцуулан, тангарагийн бичгийг тангараг өргөгчид гардуулна.

2.6. Тангараг өргөх прокурор тусгайлан бэлтгэсэн байрлалд Монгол Улсын төрийн сүлд рүү эгц харж зогсоно.

2.7. Тангараг өргөх үед ёслолын ажиллагаанд оролцогчид босч хүндэтгэл үзүүлнэ.

2.8. Тангарагийг хамтаар буюу дангаар өргөж болно. Хамтаар өргөж байгаа тохиолдолд энэ журмын 2.4-д заасны дагуу томилогдсон прокурор нь тангарагийг цээжээр дээдлэн дуудаж, бусад нь дагалдана.

2.9. Тангараг өргөсний дараа тангараг өргөгч Монгол Улсын төрийн сүлдэнд мэхийн ёсолж, зүүн өвдөгөөрөө сөхрөн Монгол Улсын төрийн далбаанаас адис авна.

2.10. Тангараг өргөсөн прокурор нь Монгол Улсын төрийн сүлд бүхий “Прокурорын тангараг”-ийн үг бүрэн бичигдсэн тангарагийн хуудаст тангараг өргөсөн он, сар, өдөр, байгууллагын нэр, овог, эцэг (эх), өөрийн нэрийг бичиж гарын үсэг зурж баталгаажуулна.

2.11. Тангараг өргөсөн прокурор тангарагийн хуудаст гарын үсэг зурж дууссаны дараа төрийн дуулал эгшиглэнэ.

2.12. Тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа прокурор тангараг өргөсөн прокуроруудад баяр хүргэж, тангараг өргөх ёслолын ажиллагааг хаана.

2.13. Тангарагийн хуудсыг тухайн прокурорын хувийн хэрэгт хавсаргаж хадгална.



2.14. Тангараг өргөх ёслолын ажиллагааны талаар тэмдэглэл хөтөлнө.

2.15. Энэ журмын хэрэгжилтэнд Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газар хяналт тавьж ажиллана.

МОНГОЛ УЛСЫН ИХ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 01 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Прокурорын зэрэг дэв тогтоох, олгох журам батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Прокурорын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. “Прокурорын зэрэг дэв тогтоох, олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 дугаар зарлигийн 3 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны
1 дүгээр сарын 31-ний өдрийн 08 дугаар
зарлигийн хавсралт

ПРОКУРОРЫН ЗЭРЭГ ДЭВ ТОГТООХ, ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь прокурорт зэрэг дэв тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болсонд тооцохтой холбоотой харилцааг зохицуулна.



1.2. Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийг хууль тогтоомжид заасан хэмжээгээр зэрэг дэв олгосон шийдвэр гарсан өдрөөс эхлэн сар бүр олгоно.

**Хоёр.Прокурорт зэрэг дэв олгох, бууруулах,
хүчингүй болсонд тооцох**

2.1. Прокурорын зэрэг дэвийг дор дурдсаны дагуу албан тушаалын ангилал, прокуророор ажилласан хугацааг харгалзан олгоно.

2.1.1. Улсын ерөнхий прокурорт албан тушаалын дагуу “Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх”;

2.1.2. Улсын ерөнхий прокурорын орлогчид албан тушаалын дагуу “Төрийн хууль цаазын шадар зөвлөх”;

2.1.3. Улсын ерөнхий прокурорын туслах прокурорт албан тушаалын дагуу “Хууль цаазын тэргүүн зөвлөх”;

2.1.4. Улсын ерөнхий прокурорын газрын ахлах прокурорт албан тушаалын дагуу “Хууль цаазын шадар зөвлөх”;

2.1.5. Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурорт прокуророор ажилласан хугацаа нь 3 жилээс дээшгүй бол “Хууль цаазын дэд зөвлөх”, 3 жилээс дээш бол “Хууль цаазын зөвлөх”, 6 жилээс дээш бол “Хууль цаазын ахлах зөвлөх, 8 жилээс дээш бол “Хууль цаазын итгэмжит зөвлөх”;

2.1.6. Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорт албан тушаалын дагуу “Хууль цаазын тэргүүн зөвлөх”;

2.1.7. Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогчид прокуророор ажилласан хугацаа нь 6 жилээс дээшгүй бол “Хууль цаазын итгэмжит зөвлөх”, 6 жилээс дээш бол “Хууль цаазын шадар зөвлөх”;

2.1.8. Нийслэлийн прокурорын газрын ахлах прокурорт прокуророор ажилласан хугацаа нь 6 жилээс дээшгүй бол “Хууль цаазын ахлах зөвлөх”, 6 жилээс дээш бол “Хууль цаазын итгэмжит зөвлөх”;

2.1.9. Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурорт прокуророор ажилласан хугацаа нь 3 жилээс дээшгүй бол “Хууль цаазын дэд зөвлөх”, 3 жилээс дээш бол “Хууль цаазын зөвлөх”, 6 жилээс дээш бол “Хууль цаазын ахлах зөвлөх”;

2.1.10. Аймаг, дагнасан прокурорын газрын ерөнхий прокурорт албан тушаалын дагуу “Хууль цаазын шадар зөвлөх”;

2.1.11. Аймаг, дагнасан прокурорын газрын ерөнхий прокурорын орлогчид албан тушаалын дагуу “Хууль цаазын итгэмжит зөвлөх”;

2.1.12. Аймаг, дагнасан прокурорын газрын ахлах прокурорт прокуророор ажилласан хугацаа нь 6 жилээс дээшгүй бол “Хууль цаазын ахлах зөвлөх”, 6 жилээс дээш бол “Хууль цаазын итгэмжит зөвлөх”;

2.1.13. Аймаг, дагнасан прокурорын газрын хяналтын прокурорт прокуророор ажилласан хугацаа нь 3 жилээс дээшгүй бол “Хууль цаазын дэд зөвлөх”, 3 жилээс дээш бол “Хууль цаазын зөвлөх”, 6 жилээс дээш бол “Хууль цаазын ахлах зөвлөх”;

2.1.14. Дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурорт албан тушаалын дагуу “Хууль цаазын шадар зөвлөх”;

2.1.15. Дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогчид албан тушаалын дагуу “Хууль цаазын итгэмжит зөвлөх”;

2.1.16. Дүүргийн прокурорын газрын ахлах прокурорт прокуророор ажилласан хугацаа нь 6 жилээс дээшгүй бол “Хууль цаазын ахлах зөвлөх”, 6 жилээс дээш бол “Хууль цаазын итгэмжит зөвлөх”;

2.1.17. Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурорт прокуророор ажилласан хугацаа нь 3 жилээс дээшгүй бол “Хууль цаазын дэд зөвлөх”, 3 жилээс дээш бол “Хууль цаазын зөвлөх”, 6 жилээс дээш бол “Хууль цаазын ахлах зөвлөх”;

2.1.18. Сум буюу сум дундын ерөнхий прокурорт албан тушаалын дагуу “Хууль цаазын итгэмжит зөвлөх”;



2.1.19. Сум буюу сум дундын прокурорын газрын хяналтын прокурорт прокуророор ажилласан хугацаа нь 3 жилээс дээшгүй бол “Хууль цаазын дэд зөвлөх”, 3 жилээс дээш бол “Хууль цаазын зөвлөх”, 6 жилээс дээш бол “Хууль цаазын ахлах зөвлөх” зэрэг дэв тус тус олгоно.

2.2. Прокурорт зэрэг дэв олгоход энэ журмын 2.1-д заасан албан тушаалын ангилал, прокуророор ажилласан хугацаанаас гадна тухайн прокурорын мэргэшсэн байдал, ур чадварыг харгалзах бөгөөд эрхэлсэн ажилдаа үр бүтээл гарган ажиллаж байгаа прокурорт албан тушаалд нь тохирох зэрэг дэвийг зохих хугацаанаас өмнө, эсхүл нэг шат дээгүүр олгож болно.

2.3. Прокурорын мэргэшсэн байдал, ур чадварыг Улсын ерөнхий прокурорын газраас тогтоосон прокурорын хяналтын ажлын чанар, үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг харгалзан үнэлнэ.

2.4. Прокурорын байгууллагын нэгж нь прокурорт зэрэг дэв олгуулах саналаа Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газарт тухайн прокурорын хяналтын ажлын чанар, үр дүнг хамт олны хурлаар хэлэлцсэн хурлын тэмдэглэл, ажил байдлын тодорхойлолтын хамт ирүүлнэ.

2.5. Тамгын газар нь энэ журмын 2.4-т заасны дагуу ирүүлсэн санал, холбогдох баримт бичгийг нягтлан судалж, Улсын ерөнхий прокурорт танилцуулан шийдвэрлүүлнэ.

2.6. Аймаг, нийслэл, дагнасан, сум буюу сум дундын, дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор нь прокуророор 23 жилээс дээш хугацаагаар ажиллаж байгаа бол ажлын үр дүн, мэргэшсэн байдал, ур чадварыг нь харгалзан “Хууль цаазын итгэмжит зөвлөх” зэрэг дэвийг олгож болно.

2.7. Прокурорт зэрэг дэв олгох асуудлыг шийдвэрлэхийн өмнө шаардлагатай бол тухайн прокурорын мэргэшсэн байдал, ур чадварын талаар Прокурорын мэргэжлийн зөвлөлөөр дүгнэлт гаргуулан судлан үзнэ.

2.8. Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагад, түүнчлэн хуульч мэргэжлээр ажиллаж байсан хүн прокуророор томилогдвол түүний ажилласан хугацаа, мэргэшсэн байдал, ур чадварыг харгалзан томилогдсон албан тушаалын ангилалд тохирох прокурорын зэрэг дэвийг шууд олгож болно.



2.9. Прокурорын албан тушаалын ангиллыг дээшлүүлэх, бууруулах тохиолдолд урьд нь олгосон зэрэг дэвийг өөрчилж, шинээр томилогдсон албан тушаалын ангилалд тохирох прокурорын зэрэг дэвийг олгоно.

2.10. Прокурорын албан тушаалд ажиллаж байгаад өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, биеийн эрүүл мэндийн байдлын улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон үндэслэлээр чөлөөлөгдсөн хүн прокуророор дахин томилогдсон тохиолдолд прокурорын тухайн албан тушаалын ангилалд тохирох зэрэг дэвийг олгоно.

2.11. Прокурор хуульд заасан үндэслэл, журмын дагуу прокурорын албан тушаалаас чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд тухайн прокурорын зэрэг дэв хүчингүй болсонд тооцно.

2.12. Прокурорын зэрэг дэв олгох хугацаа болсон боловч мэргэшлийн түвшин хангалтгүй, прокурорын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд тухайн албан тушаалын ангилалд тохирох зэрэг дэвийг олгохгүй.

2.13. Ажлаас халагдахаас бусад сахилгын шийтгэл хүлээсэн, түүнчлэн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд эрхэлсэн ажилдаа тэнцэхгүй тухай мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарч, албан тушаал бууруулсан тохиолдолд уг прокурорын зэрэг дэвийг бууруулж болно.

2.14. Прокурорын тухай хууль болон энэ журамд заасны дагуу прокурорт олгосон зэрэг дэвийг бууруулах буюу хүчингүй болгоно.

Гурав. Бусад зүйл

3.1. Прокурорын зэрэг дэвийг тодорхойлох нэг зүйл нь прокурорын дүрэмт хувцас дээрхи түүнд олгосон зэрэг дэвийн мөрдэс байна.

3.2. Прокурор нь өөрт олгогдсон зэрэг дэвийн мөрдэсийг батлагдсан загвар, хэмжээний дагуу хэрэглэнэ.

3.3. Прокуророор шинээр томилогдсон хүнд прокуророор томилсон тухай Улсын Ерөнхий прокурорын тушаал танилцуулах үед зэрэг дэвийн мөрдэсийг хүндэтгэлтэй гардуулж өгнө.



3.4. Прокурор нь олгогдсон зэрэг дэв, түүний мөрдөст хүндэтгэлтэй хандах бөгөөд энэ журамд заасны дагуу өөрт олгогдоогүй прокурорын зэрэг дэвийн мөрдэсийг хэрэглэхийг хориглоно.

3.5. Энэ журмын хэрэгжилтэнд Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газар хяналт тавьж ажиллана.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 200003